



**“МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ  
ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН  
(2025 оны жилийн эцэс)**

2026 оны 02 сарын 09

Улаанбаатар хот

**Нэг. Хяналт-шинжилгээний  
зорилго, үндэслэл, арга зүй**

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, Засгийн газарт хэрэгжилтийг тайлагнах, яамны удирдлага, албан тушаалтныг мэдээллээр хангах, үр дүнг сайжруулах зөвлөмж өгөх, төлөвлөсөн арга хэмжээг хугацаанд нь хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын 6.1-д заасан аргачлалаар тооцож, үр дүнг 6.5-д заасны дагуу дүгнэсэн.

**Хоёр. Төлөвлөсөн арга хэмжээний  
хэрэгжилтийн байдал**

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын дагуу үнэлэхэд 53 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 60.46 хувь, Төсвийн ерөнхийлөн захирагчийн шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт 100 хувь, хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт 81.77 хувь, тэргүүлэх чиглэлийн 15 зорилтын хэрэгжилт 62.3 хувийн үнэлгээтэй байна.

2.1. Төсөл арга, хэмжээний хэрэгжилтийг үнэлж 0-29 хувьтай буюу “үр дүн гараагүй” арга хэмжээг Хүснэгт №1-д харуулав.

*“0-29” хувийн хэрэгжилттэй  
төсөл, арга хэмжээ*

Хүснэгт №1

Д/д	Дугаар	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилгот түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэлийн хувь
1	1.5.2.5.	Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой Баруун наран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс "Цагаандэл уул" хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын авто зам барих	Барилгын ажлын гүйцэтгэл	0	50	0.1	0.2
2	1.8.3.8.	Баруун-Урт-Бичигт чиглэлийн хатуу хучилттай 180 км авто зам барих	Барилгын ажлын гүйцэтгэл	0	20	5.1	25.5

2.2. Төсөл арга, хэмжээний хэрэгжилтийг үнэлж 30-59 хувийн хэрэгжилттэй буюу “үр дүн хангалтгүй” арга хэмжээг Хүснэгт №2-т харуулав.

“30-59” хувийн хэрэгжилттэй  
төсөл, арга хэмжээ

Хүснэгт №2

Д/д	Дугаар	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилгот түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэлийн хувь
1	1.5.2.3.	Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавиргын боомт чиглэлийн 124.5 км хатуу хучилттай авто зам барих	Барилгын ажлын гүйцэтгэл	30	55	41.25	45%
2	1.5.2.9.	Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төслийн 3 дугаар үе шатны төслийг хэрэгжүүлэх	Барилгын ажлын гүйцэтгэл	0	60	8.72	57.2%
3	1.5.2.13.	Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэлийн хатуу хучилттай 152.5 км авто зам барих	Барилгын ажлын гүйцэтгэл	20	35	17.7	50.5%
4	1.8.3.4.	Бор-Өндөр-Хэрлэн чиглэлийн хатуу хучилттай 179.7 км авто зам барих	Барилгын ажлын гүйцэтгэл	10	30	20.2	51%
5	1.8.3.5.	Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн хот хоорондын А0301 авто замаас Өвөрхангай аймгийн Хужирт сумтай холбох хатуу хучилттай 43.3 км авто зам барих	Барилгын ажлын гүйцэтгэл	30	70	48	45%
6	1.8.3.9.	Баянхонгор-Шаргалжуут чиглэлийн хатуу хучилттай 54.18 км авто зам барих	Барилгын ажлын гүйцэтгэл	20	50	36	53%
7	1.8.3.16.	Булган, Орхон, Хишиг-Өндөр, Гурванбулаг чиглэлийн 133.7 км хатуу хучилттай авто замын 99.6 км авто зам барих	Барилгын ажлын гүйцэтгэл	50	100	70	40%
8	1.8.3.18.	Норовлин сумаас Баян-Уул чиглэлийн 68.3 км хатуу хучилттай авто зам барих	Барилгын ажлын гүйцэтгэл	60	100	75	37.5%
9	1.8.3.19.	Хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай авто замтай Цэцэг сумыг холбох 32.4 км авто зам барих	Барилгын ажлын гүйцэтгэл	15	70	42.5	50%

2.3. “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-нд туссан, шалгуур үзүүлэлтийг “барилгын ажлын гүйцэтгэлийн хувь”-аар тооцохоор батлагдсан 20 төсөл, арга хэмжээ нь одоогоор ТЭЗҮ боловсруулах, зураг төсөл боловсруулах болон худалдан авах ажиллагааны шатанд хэрэгжиж байна. Иймд 20 төсөл, арга хэмжээ болон “Боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх” зорилтын хүрээнд туссан 2 төсөл, арга хэмжээг “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын 6.1-д заасан аргачлалын дагуу үнэлэх боломжгүй байгаа тул хэрэгжилтийн явцыг харгалзан 30 хувиар үнэлэн Хүснэгт №3-д харуулав.

Шалгуур үзүүлэлтээс хамаарч 30 хувиар үнэлсэн  
төсөл, арга хэмжээний жагсаалт

Хүснэгт №3

Д/д	Дугаар	Төсөл, арга хэмжээ	Батлагдсан шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт
1.	Төмөр замын салбар			

1	1.5.1.2.	Ханги-Мандал хилийн боомтын хил дамнасан төмөр зам болон ачаа тээврийн шилжүүлэн ачих терминал барих;	Барилгын ажлын гүйцэтгэл	Дэд ажлын хэсгийн ажлыг эрчимжүүлэх, төслийн ажил дэмжлэг үзүүлэх тухай 2025.10.09-ний өдрийн 02/4665, 02/4666 дугаар албан бичгийг Гадаад харилцааны сайд, Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яаманд тус тус хүргүүлсэн.
2	1.5.1.3.	Арцсуурь-Шивээхүрэн-Нарийнсухайт чиглэлийн 1255 км төмөр замын төслийн хүрээнд Шивээхүрэн-Нарийнсухайт-Шинэжинст чиглэлийн 300 км төмөр зам барих	Барилгын ажлын гүйцэтгэл	Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг Төмөр замын тээврийн салбарын Шинжлэх ухаан, технологийн салбар дэд зөвлөлөөр 2025.09.04, 2025.11.12-нд 2 удаа хэлэлцүүлж, санал зөвлөмжийн дагуу ТЭЗҮ-д холбогдох сайжруулалт, нэмэлт өөрчлөлтийг тусгасны дагуу Зам, тээврийн яамны салбар зөвлөлөөр хэлэлцүүлэхээр шийдвэрлээд байна.
3	1.5.1.4.	Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн 426.7 км төмөр замын төслийн хүрээнд Бичигт-Зүүнхатавч боомтын хил холболтын төмөр зам барих;	Барилгын ажлын гүйцэтгэл	Монголын төмөр зам ТӨХК Бичигт-Зүүнхатавч хил дамнасан төмөр замын ТЭЗҮ-ийг боловсруулж ЗТЯ-ны ШУТЗ-өөр хэлэлцүүлж, зөвлөмж авсан. ТЭЗҮ-г сайжруулахаар ажиллаж байна.
4	1.5.1.5.	Чойбалсан-Бичигт чиглэлийн босоо тэнхлэгийн төмөр зам барих;	Барилгын ажлын гүйцэтгэл	Чойбалсан-Хөөт- Бичигт чиглэлийн төмөр замын “Инженерийн урьдчилсан зураг төсөл” /FEED/- ийн тайлангийн техникийн үзүүлэлт, ажлын тоо хэмжээнд тулгуурлан урьдчилсан үнэлгээ хийж, Зам, тээврийн яаманд 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 01/372 дугаартай албан бичгээр ирүүлсэн, тус урьдчилсан үнэлгээг хянаж, эдийн засгийн тооцооллыг дахин сайжруулах чиглэлийг хүргүүлсэн.
5	1.5.1.6.	“Шивээхүрэн-Сэхээ” хил холболтын төмөр зам барих;	Барилгын ажлын гүйцэтгэл	Шивээхүрэн-Сэхээ боомтын хил дамнасан төмөр замын Ажлын хэсэг байгуулахаар ЭЗХС-ын тушаалын төсөл, танилцуулгыг боловсруулж, ЗТС-ын 2025.12.04-ний өдрийн 01/5622 дугаар бичгээр хүргүүлээд байна.
<b>2.Иргэний нисэхийн салбар</b>				
6	1.8.2.1.	“Ховд” нисэх буудлыг 4С ангиллын болгон хүчин чадлыг нэмэгдүүлж, ашиглалтыг сайжруулах төсөл хэрэгжүүлэх;	Барилгын ажлын гүйцэтгэл	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу төслийг нийтэд урьдчилан зарлах ажиллагаа хүлээгдэж байна.
7	1.8.2.2.	“Мөрөн” нисэх буудлыг 4С ангиллын болгон хүчин чадлыг нэмэгдүүлж, ашиглалтыг сайжруулах төсөл хэрэгжүүлэх;	Барилгын ажлын гүйцэтгэл	2026 онд ТЭЗҮ боловсруулах ажлыг эхлүүлнэ.
8	1.8.2.4.	Дорнод аймгийн Буйр нуур орчимд 4С нисэх буудал байгуулах;	Барилгын ажлын гүйцэтгэл	Одоогийн байдлаар Дорнод аймгийн Халхгол сумруу зорчигч урсгал бага, эрэлт байхгүй, зэргэлдээ 400км-т орших нисэх буудлыг Олон улсын иргэний нисэхийн 4С ангиллын нисэх

**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ**

				буудал болгон өргөжүүлэхээр Засгийн газрын бодлого баримтлан ажиллаж байх тул нэн шаардлагатай биш гэж үзэн хасах саналтай байна.
9	1.8.2.5.	“Гурвансайхан” нисэх буудлыг 4D ангиллын болгон хүчин чадлыг нэмэгдүүлж, ашиглалтыг сайжруулах төсөл хэрэгжүүлэх;	Барилгын ажлын гүйцэтгэл	2026 онд ТЭЗҮ боловсруулах ажлыг эхлүүлнэ.
<b>Авто замын салбар</b>				
10	1.5.2.1.	Дархан-Алтанбулаг чиглэлийн 113.1 км, 4 эгнээ хатуу хучилттай авто замын өргөтгөл, 885.6 у/м гүүрэн байгууламжийн ажлыг эхлүүлэх;	Барилгын ажлын гүйцэтгэл	ЭЗХЯ-наас 2025 оны 03/1417 тоотор Төр, хувийн хэвшлийн хуулийн дагуу төслийн бүрэн шинжилгээ хийх багт ажиллах 3 албан хаагчийн мэдээлэл ирүүлэхийг хүссэний дагуу тус яамнаас 2025.06.05-ны 03/2630 тоотор төслийн багт ажиллах албан хаагчдын нэрсийг хүргүүлсэн боловч одоогоор төслийн багийг хуралдуулаагүй, ямар нэгэн шийдвэр гаргаагүй байна.
11	1.5.2.2.	Налайх-Замын-Үүд чиглэлийн авто замыг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчлэх;	Барилгын ажлын гүйцэтгэл	Төслийн санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Сангийн яам болон Азийн хөгжлийн банкинд саналыг хүргүүлсэн
12	1.5.2.7.	Улаанбаатар-Шар хөтөл-Эрдэнэт чиглэлийн хатуу хучилттай авто замын эхлэл, 92.13 км авто зам барих;	Барилгын ажлын гүйцэтгэл	ТХААГ-аас тендер зарласан боловч гүйцэтгэгч шалгараагүй тул уг төсөл төсвийн тодотголоор хасагдсан.
13	1.5.2.8.	Бургастай хилийн боомтыг 320 км хатуу хучилттай авто замаар холбох төслийг хэрэгжүүлэх;	Барилгын ажлын гүйцэтгэл	Зураг төслийг хийж гүйцэтгэж байна.
14	1.5.2.17.	Баяндалай-Гурвантэс чиглэлийн 80 км хатуу хучилттай авто замын дуусгал, 74.2 км авто замын төслийг хэрэгжүүлэх;	Барилгын ажлын гүйцэтгэл	МУ-ын 2026 оны оны төсөвт Баяндалай-Гурвантэс чиглэлийн 80 км хатуу хучилттай авто замын үргэлжлэл болох 37 км авто замын хөрөнгө оруулалт шийдвэрлэгдсэн. Гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг Төрийн худалдан авах ажиллагааны газар зохион байгуулна.
15	1.8.3.6.	Хэрлэн-Тосон-Уул-Халх гол чиглэлийн хатуу хучилттай 256 км авто зам барих;	Барилгын ажлын гүйцэтгэл	Хэрлэн - Халх гол чиглэлийн хатуу хучилттай авто замын зураг төслийг боловсруулсан. 2025 оны Улсын төсвийн тухай хуульд тусгуулахаар санал хүргүүлсэн боловч тусгагдаагүй
16	1.8.3.11.	Налайх-Тэрэлж чиглэлийн 37 км авто замыг 4 эгнээ болгон өргөтгөх;	Барилгын ажлын гүйцэтгэл	2025 оны Улсын төсвийн тухай хуульд тусгуулахаар санал хүргүүлсэн боловч тусгагдаагүй.



**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ**

17	1.8.3.13.	Улаанбаатар-Лүн чиглэлийн авто замд байрлах Лүнгийн 327 у/м гүүрийг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчлэх;	Барилгын ажлын гүйцэтгэл	Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэхээр Сангийн яам болон Аравын эдийн засгийн хөгжлийн Кувейтын санд төслийн саналыг хүргүүлсэн.
18	1.8.3.14.	Улаанбаатар-Лүн чиглэлийн 101.7 км авто замыг 4 эгнээ болгон өргөтгөн шинэчлэх.	Барилгын ажлын гүйцэтгэл	ЗТЯ-аас төслийн нарийвчилсан зураг, төсөв өртгийг магадлангаар баталгаажуулан 2025.06.10-ны өдөр хариу ирүүлснээр, төсөл хэрэгжүүлэх санал, хүсэлтийг Кувейтын санд хүргүүлсэн байна.
<b>Боомтын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.</b>				
19	1.6.1.6.	Өмнөговь аймгийн Гурвантэс суманд “Шивээхүрэн нурмаг ачааны терминал” барих;	Барилгын ажлын гүйцэтгэл	Өмнөговь аймгийн Гурвантэс суманд “Шивээхүрэн нурмаг ачааны терминал” барих арга хэмжээний зорилтот түвшин, санхүүжилт тодорхойгүй байгаа бөгөөд, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж эхлээгүй байна.
20	1.6.1.7.	Өмнөговь аймгийн Гурвантэс суманд “Нийтийн зориулалтын тээвэр логистик, агуулахын терминал” барих;	Барилгын ажлын гүйцэтгэл	

Хүснэгт №3-т туссан 20 төсөл, арга хэмжээнээс төмөр замын салбарын 5, иргэний нисэхийн салбарын 4, авто замын салбарын 11, “Боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх” зорилтын хүрээнд туссан 2 арга хэмжээ байна.

2.4. “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-нд туссан 51 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлж, уг төлөвлөгөөг эзэнжүүлсэн төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийн үнэлгээг холбогдох газруудаар гаргаж, Хүснэгт №4-т харуулав.

*Төсөл, арга хэмжээний биелэлт  
/Хариуцсан газраар/*

*Хүснэгт №4*

Хариуцсан газар	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь
АЗБЗГ	2	38	65.1%
ТЗТБЗГ	1	6	40.7%
ИНБЗГ	1	6	53.3%
АТБЗГ	1	1	100%
Нийт	6	51	60.4%

Төрийн нарийн бичгийн даргын баталсан Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд зам, тээврийн чиглэлээр тусгагдсан төсөл, арга хэмжээг эзэнжүүлэх төлөвлөгөөнд “Боомтын хүчин чадлыг нэмэгдүүлнэ” зорилтын хүрээний төсөл, арга хэмжээг хариуцах эзэнг тодорхой болгоогүй байна.

2.5. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын 6.5-д заасны дагуу бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээг холбогдох газруудаар гаргаж, Хүснэгт №5-т харуулав.

*Төсөл, арга хэмжээний биелэлт  
/Хариуцсан газраар/*

*Хүснэгт №5*

Газруудын нэр	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн явц зорилтот түвшин				Хэрэгжилтийн хувь
		85 хувь буюу түүнээс	60-84 хувь буюу “үр дүн	30-59 хувь буюу “үр дүн хангалтгүй”	0-29 хувь буюу “үр	



## ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

		дээш "үр дүнтэй"	хүлээгдэж байгаа"		дүн гараагүй"	
АЗБЗГ	38	16	2	18	2	65.1%
ТЗТБЗГ	6	1	-	5	-	40.7%
ИНБЗГ	6	2	-	4	-	53.3%
АТБЗГ	1	1	-	-	-	100%
Нийт	51	20	2	27	2	<b>60.4%</b>

### Гурав. Дүгнэлт

3.1. "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан "Хяналт-шинжилгээ хийх журам"-ын дагуу үнэлэхэд 53 төсөл, арга хэмжээний хэрэгжилт 60.4%, 15 тэргүүлэх чиглэлийн хэрэгжилт 62.3%-ийн үнэлгээтэй буюу "үр дүн хүлээгдэж байгаа", Төсвийн ерөнхийлөн захирагчийн шалгуур үзүүлэлтийн үнэлгээ 100 хувьтай, хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн үнэлгээ 81.8 хувийн хэрэгжилттэй, зорилтот түвшний 85 хувиас дээш буюу "үр дүн гарсан" гэж үнэлэгдсэн.

3.2. Монгол Улсын төсвийн тухай хуульд тусгуулахаар санал хүргүүлсэн боловч хасагдсан, санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагад санал хүргүүлсэн, тендер зарласан боловч гүйцэтгэгч шалгараагүй, ТЭЗҮ, зураг төслийн шатанд яваа, санхүүжилт шийдвэрлэгдээгүй, Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн хүрээнд төслийн шинжилгээ хийж байгаа энэхүү тайлангийн 2.3-т дурдсан барилгын ажил эхлээгүй 20 төсөл, арга хэмжээний "шалгуур үзүүлэлт"-ийг "барилгын ажлын гүйцэтгэл"-ийн хувиар тооцохоор батлуулсан нь тухайн бодлогын бичиг баримтын хэрэгжилт хангалтгүй үнэлэгдэхэд нөлөөлж байна.

3.3. Мөн бодлогын баримт бичгүүдийг уялдуулаагүй буюу төсөл, арга хэмжээний 2025 онд хүрэх түвшинг "зөрүү"-тэй батлуулсан байна. **Тухайлбал:** Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 691, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний 1.8.3.16-д заасан авто замын салбарын бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээ, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 640, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний 1.8.2.1, 1.8.2.2, 1.8.2.3, 1.8.2.5-д заасан иргэний нисэхийн салбарын бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээ гэх мэт.

3.4. Цаашид бодлогын баримт бичгүүдийн төсөлд санал хүргүүлэхдээ төлөвлөлтийг уялдуулах, "шалгуур үзүүлэлт", "зорилтот түвшин"-г бүтээн байгуулалтын ажлын явц болон холбогдох хууль тогтоомжид нийцүүлж үнэн зөв, бодитой тодорхойлж, салбарын хэмжээнд бодлогын хүрээнд холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй гэж дүгнэж байна.

### Дөрөв. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан Зам, тээврийн салбарт хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

#### 4.1. Бодлого, төлөвлөлтийн газарт:

- Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөг "эзэнжүүлэх төлөвлөгөө"-г батлуулах;
- Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд саналаа өгөхдөө урт болон дунд хугацааны бодлогын баримт бичиг, төсөл, арга хэмжээний бүтээн байгуулалтын явц болон судалгаанд суурилсан тухайн жилд хэрэгжүүлэх боломжит шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин бүхий төсөл, арга хэмжээг тусгаж ажиллах;
- Салбарын хэмжээнд хэрэгжиж байгаа бодлогын баримт бичгүүдэд туссан төсөл, арга хэмжээний "шалгуур үзүүлэлт", "зорилтот түвшин" зэргийг уялдуулан

хэрэгжилтийг бүрэн хангах ажлын хүрээнд цаашид авах арга хэмжээний санал боловсруулж 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор яамны удирдлагад танилцуулах;

4.2. Яамны газар, хэлтсүүдэд:

- Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд туссан төсөл, арга хэмжээг яам, нэгж, харьяа байгууллага, албан хаагчдын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бүрэн тусгах;
- Тайлангийн боловсруулалтад анхаарч, тэргүүлэх чиглэлд туссан зорилго зорилтын хүрээнд хийсэн ажлыг бүрэн тайлагнах, мөн шалгуур үзүүлэлтийн тоон мэдээлэл, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулсан санхүүжилт болон үр дүнг нотлох баримтын хамт хавсарган иж бүрэн тайланг гаргаж, хянан баталгаажуулж Бодлого төлөвлөлтийн газарт хүргүүлж ажиллах;
- Үр дүнд хүрээгүй зорилт арга хэмжээний шалтгаан, нөхцөлийг тайланд үнэн зөв дурдах;
- Төсөл, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд хүрэхгүй байх эрсдэлийг урьдчилан тооцоолж, хариу арга хэмжээг шуурхай авч ажиллах;
- Зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллан, Зам, тээврийн сайдын 2025 оны А/310 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлж, дүгнэх журам”-ын 6 дугаар хавсралтад заасны дагуу 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдөрт багтаан Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлж ажиллахыг тус тус зөвлөж байна.

---o0o---